

“ЭРДЭНЭС ҮНДЭСНИЙ СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ” ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

“Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв” ХХК нь Монгол Улсад дэвшилтэт технологийн судалгаа шинжилгээ, туршилтын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, оюуны багтаамжтай өндөр технологийг нутагшуулах, инноваци, инженерингийг хөгжүүлэх, судлаачдын мэдлэг оюуныг нэгтгэн улсын хөгжилд тус нэмэр оруулах, эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бизнесийг дэмжиж тэдгээрт ажил үйлчилгээ үзүүлэх, сургалт судалгаа явуулах, хууль эрх зүйн зөвлөлгөө өгөх зорилгоор байгуулагдсан.

БИДНИЙ АЛСЫН ХАРАА:

Дэвшилтэт техник технологийн ололтыг эрэлхийлсэн Олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны төв байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Эрдэм шинжилгээ судалгааны үр дүнд үндэслэсэн шийдлийг гаргах, нэвтрүүлэх, мэдлэгт суурилсан дэвшилтэт техник, технологийг эрхэмлэсэн шинжлэх ухааны төв байхад оршино.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ:

- Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг бэхжүүлэх, үйлдвэрлэгчид, ажил хэрэгч хүмүүст зөвлөх үйлчилгээ үзүүлэх, түншүүдтэй гэрээгээр хамтран ажиллах;
- Техник, технологийн судалгааг тасралтгүй явуулах, оюуны өмч бүрдүүлэх, эрдэмтэн, судлаачдын бүтээлийг дотоод гадаадад сурталчлах, үнэлүүлэх болон түүний эрхийг хамгаалах;
- Эрдэмтэн, судлаачдын судалгааны ажлыг дэмжих, харилцан туршлага солилцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, чуулга уулзалт, сургалт семинар зохион байгуулах;
- Үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, технологийн инновацийг хөгжүүлэхэд чиглэгдсэн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг менежментийн удирдлагаар хангах;
- Монгол улсын эрдэс баялгийн бодлого, зохицуулалт, техникийн стандартуудын өөрчлөлт зэрэг асуудлуудаар төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд төрийн үйлчилгээг улам ойртуулахад туслалцаа үзүүлэх;
- Эрдэс баялгийн салбарт ажиллагсдын нийгмийн асуудал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, шагнал урамшуулал, мэргэжил дээшлүүлэх, тус салбарт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын үйл ажиллагаа явуулах ажлын байрны орчин, нөхцлийг сайжруулах тал төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;


“ЭРДЭНЭС ҮНДЭСНИЙ СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ” ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ:

- Уул уурхайн салбарын бодлогын судалгаа;
- Уул уурхайн байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа;
- Баяжуулалтын технологийн судалгаа (технологийн сонголт, урвалжийн зарцуулалт, технологийн үнэлгээ гэх мэт);
- Хагас үйлдвэрлэлийн туршилт, судалгаа;
- Уул уурхайн салбарын удирдлага, хөрөнгө оруулалтын үр ашгийн судалгаа;
- Уул уурхайн үйлдвэрийн технологийн процесийн иж бүрэн автоматжуулалтын судалгаа;
- Геоэкологи, гидрогеологи болон бусад сэдэвчилсэн судалгаа; Хээрийн судалгааны ажил;
- Байгаль орчинд хал багатай техник, технологийн судалгаа;
- Технологийн түвшний үнэлгээ;
- Бүс нутгийн хөгжил, үйлдвэрлэл технологийн паркийн судалгаа



“УУЛ УУРХАЙ-МЕТАЛЛУРГИ-ХИМИЙН ҮЙЛДВЭРИЙН ЦОГЦОЛБОР” ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК БАЙГУУЛАХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ХАВСРЫН



БИДНИЙ ТУРШЛАГА:

Манай судалгааны баг гадаад, дотоодын дараах эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудад гүйцэтгэгч, удирдагчаар оролцож, туршлага хуриатлуулан салбартай танигдсан болно. Үүнд:




Патент:

Ашигтай загварын гэрчилгээ, зохиогчийн эрх 15 хамгаалсан.

Төсөл, судалгаа:

“Эрдэнэтийн зэс цувималын үйлдвэр” төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;



- “Үндэсний цогц бодлогийг боловсруулах” төсөл;
- “Монгол Улсын Эрдэс баялгийн цогцолборын талаар баримтлах төрийн бодлого”, төсөл;
- “Ховд гол”-ын вольфрамитын ордыг түшиглэн байгуулах баяжуулах үйлдвэрийн төсөл;



- Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл технологийн парк байгуулах ТЭЗҮ;
- “Газрын ховор металлыг эрдэс түүхий эдээс гүн боловсруулах өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх боломж” ТЭЗУС. Эдийн засгийн хөгжлийн яам;

“ЭРДЭНЭС ҮНДЭСНИЙ СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ” ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Б. Хөнгөн үйлдвэр

Патент:

Ашигтай загварын гэрчилгээ, зохиогчийн эрх 5 хамгаалсан.


Төсөл, судалгаа:

“Малын дайвар бүтээгдэхүүнийг боловсруулан шинэ материал гарган авах технологи”;



- “Шинэ аж үйлдвэржилтийн бодлого” ШУТ-ийн төсөл;
- “Монгол Улсын аж үйлдвэрийн хөгжилд чиглэсэн технологи сонгох стратеги” шинжлэх ухаан, технологийн төсөл;

- Улаанбаатар хотын тэргүүлэх чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийн судалгаа;
- Төв аймгийн Зуунмод Үйлдвэрлэл технологийн паркийн Мастер төлөвлөгөө боловсруулах;
- “Хөнгөн үйлдвэрийн салбарт ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн насжилт, технологийн түвшний үнэлгээ” судалгааны ажил;
- “Дархан, Сэлэнгийн бүсэд Шинжлэх ухааны парк байгуулах боломжийн судалгаа” ТЭЗУС;
- “Багануурын ҮТП-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээ;



Манай компаний давуу тал бол ажиллах боловсон хүчний нөөц, ажлын туришлага, ур чадвар, мэргэшсэн байдал бөгөөд сүүлийн 30 гаруй жил геологи, уул уурхайн, хөнгөн, хүнд үйлдвэр болон байгаль орчны чиглэлээр судалгаа шинжилгээний ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн мэргэжлийн, туришлагатай хамт олноор багаа бүрдүүлж чадсан явдал юм.

Хаяг: УБ хот, СБД, 8-р хороо, Бага Тойруу, Нийслэл аудит, I орц, 401 тоот

Утас: 11-319973
И-мэйл: info@rdc.mn
Веб хуудас: www.rdc.mn